



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дэвшил сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2025/137/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Улиастай сум
2025 он

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа
Утас: 99993365
Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn
Аудитын менежер: Х.Болдбаатар
Утас: 99105506
Цахим хаяг: Boldbaatarkh@audit.gov.mn
Хаан соёмбо аудит ХХК -гэрээт аудитор:
Б.Цэрэндэжид
Утас: 99812811
Цахим хаяг: tserendejid1109@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	8
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	8
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	11
4. Аудитын тайлан.....	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. Аудитын илрүүлэлт	16
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс:7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn.

2025.02.21 № 148

танай _____ -ны № _____ -т

УЛИАСТАЙ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН ДЭВШИЛ
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Д.МӨНХДЭЛГЭР-Т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улиастай сумын Ерөнхий боловсролын Дэвшил сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улиастай сумын Ерөнхий боловсролын Дэвшил сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Улиастай сумын Ерөнхий боловсролын Дэвшил сургууль нь 2024 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 48 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж, биелэлт 97 хувьтай байна. Гүйцэтгэлийн үнэлгээнд 54 багш хамрагдсанаас II индексээр 13 багш, III индексээр 13 багш, IV индексээр 10 багш үнэлэгдэж, байгууллагын үнэлгээгээр V түвшинд үнэлэгдсэн байна.

Улиастай сумын Ерөнхий боловсролын Дэвшил сургууль нь 2024 онд 3,026,024.8 мянган төгрөгийн санхүүжилттэй, 298,964.5 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй, цахим ангийн тоног төхөөрөмж, утасгүй интернет төхөөрөмжийн 84,858.9 мянган төгрөгийн өглөгтэй ажилласан байна.

Аудитын гол асуудал

Улиастай сумын Ерөнхий боловсролын Дэвшил сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар хүүхдийн үдийн хоолыг норматив зардлаас 2,588.4 мянган төгрөгөөр дутуу олгосон байна.

Бусад асуудлын хэсэг

Улиастай сумын Ерөнхий боловсролын Дэвшил сургууль нь төсвийн хөрөнгөөр 46,359.7 мянган төгрөгийн тавилга эд хогшил, тоног төхөөрөмж худалдан авч, Боловсролын ерөнхий газрын хөрөнгө оруулалтаар 35,767.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, сумын Орон нутгийн хөгжлийн сангаас 8,817.6 мянган төгрөгийн локер

D:/disk/Албан бичиг/Дүгнэлт

812500054

нийлүүлэгдсэнийг данс бүртгэлд тусгасан байна. Тус сургууль нь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 168 дугаар тоотоор 24 нэр төрлийн 163 ширхэг 52,641.7 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоож 15,959.8 мянган төгрөгөөр бүртгэсэн байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/58 дугаар захирамжаар 60,624.6 мянган төгрөгийн хөрөнгийг, Улиастай сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 07 дугаар тогтоолоор 1,773.0 мянган төгрөгийн тавилга эд хогшлыг акталж данс бүртгэлээс хассан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31		/төгрөгөөр/	
Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	333,434,284.66	488,601,869.90
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	217,488,975.96	298,964,501.10
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	217,488,975.96	298,964,501.10
3121	Төгрөг	217,488,975.96	298,964,501.10
31211	Төрийн сангийн харилцах	217,488,975.96	298,964,501.10
33	АВЛАГА	82,926.00	
331	Ажиллагчидтай холбогдсон авлага	82,926.00	
35	БАРАА МАТЕРИАЛ	115,862,382.70	189,637,368.80
351	Түүхий эд материал	526,380.00	477,440.00
3513	Эм боох материал	526,380.00	477,440.00
354	Хангамжийн материал	115,336,002.70	189,159,928.80
3541	Бичиг хэргийн материал	4,553,150.00	3,071,150.00
3542	Аж ахуйн материал	9,654,609.00	15,641,179.00
3545	Барилгын засварын материал	35,205,600.00	31,667,000.00
3546	Хүнсний материал	4,687,400.00	1,128,000.00
3547	Бусад хангамжийн материал	61,235,243.70	137,652,599.80
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,155,635,659.71	2,141,160,325.77
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,155,635,659.71	2,141,160,325.77
392	Биет хөрөнгө	2,055,520,784.71	2,041,217,325.77
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,863,985,492.00	1,854,685,492.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-202,394,206.32	-229,399,352.52
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	345,994,592.31	397,275,399.21
39206	Хуримтлагдсан элэгдэл	-160,417,882.70	-157,453,155.47
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	285,943,762.25	293,079,738.25
39208	Хуримтлагдсан элэгдэл	-117,280,425.83	-156,730,592.70
39217	Ном	39,689,453.00	39,759,797.00
393	Биет бус хөрөнгө	100,114,875.00	99,943,000.00
39301	Програм хангамж	2,530,000.00	
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,358,125.00	
39303	Бусад биет бус хөрөнгө	99,943,000.00	99,943,000.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,489,069,944.37	2,629,762,195.67
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР		84,858,900.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		84,858,900.00
413	Өглөг		84,858,900.00
4136	Бусад өглөг		84,858,900.00
41361	Байгууллагад төлөх өглөг		84,858,900.00
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,489,069,944.37	2,544,903,295.67
51	Засгийн газрын хувь оролцоо Засгийн газрын оруулсан капитал /Засгийн	2,489,069,944.37	2,544,903,295.67
511	газрын сан/ орон нутгийн сан	744,596,274.90	744,596,274.90
51101	Өмч: - төрийн	744,596,274.90	744,596,274.90
512	Хуримтлагдсан үр дүн	1,304,737,199.73	1,344,610,682.13
5121	Өмнөх үеийн үр дүн	1,304,737,199.73	1,304,737,199.73
5122	Тайлант үеийн үр дүн		39,873,482.40
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	439,736,469.74	455,696,338.64

VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,489,069,944.37	2,629,762,195.67
----	--	------------------	------------------

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31		/төгрөгөөр/	
Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,379,810,483.99	3,098,248,304.10
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	173,823,883.99	90,050,904.10
120	Нийтлэг татварын бус орлого	173,823,883.99	90,050,904.10
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	121,988,679.06	17,827,400.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	103,335,679.06	11,153,400.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	18,653,000.00	6,674,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	45,389,856.23	49,144,695.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	6,445,348.70	23,078,809.10
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,205,986,600.00	3,008,197,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,923,642,200.00	2,673,392,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,923,642,200.00	2,673,392,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	282,344,400.00	334,804,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	282,344,400.00	334,804,700.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,260,688,168.69	3,053,885,165.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,260,688,168.69	3,053,885,165.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,134,496,211.80	2,922,122,040.63
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,420,059,793.29	1,994,700,715.96
210101	Үндсэн цалин	960,057,528.97	1,287,776,672.56
210102	Нэмэгдэл	402,970,219.24	624,885,003.40
210104	Урамшуулал	57,032,045.08	82,039,040.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	176,203,722.48	247,552,545.38
210201	Тэтгэврийн даатгал	121,195,175.35	170,675,224.33
210202	Тэтгэмжийн даатгал	14,207,212.30	20,031,528.43
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,321,949.83	9,962,964.45
210204	Ажилгүйдлийн даатгал	2,679,998.65	9,376,565.74
210205	Эрүүл мэндийн даатгал	26,799,386.35	37,506,262.43
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	273,659,503.11	329,803,931.33
210301	Гэрэл, цахилгаан	14,901,103.11	14,362,811.33
210302	Түлш, халаалт	244,832,400.00	291,573,100.00
210303	Цэвэр, бохир ус	13,926,000.00	23,868,020.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,474,700.00	8,923,400.00
210604	Урсгал засвар	10,474,700.00	8,923,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,986,511.43	19,813,613.16
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,115,430.00	6,500,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	13,871,081.43	13,313,613.16
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	232,111,981.49	321,327,834.80
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	76,747,503.07	124,458,158.16
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	19,553,300.00	25,187,435.20
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	135,811,178.42	171,682,241.44
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	126,191,956.89	131,763,124.67
2132	Бусад урсгал шилжүүлэг	121,882,060.00	131,762,356.00

213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	121,882,060.00	131,762,356.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,309,896.89	768.67
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,309,896.89	768.67
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	119,122,315.30	44,363,138.80
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	19,118,927.47	4,489,656.40
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	19,118,927.47	4,489,656.40
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-19,118,927.47	-4,489,656.40
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	100,003,387.83	39,873,482.40

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,327,975,279.06	3,026,024,800.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	121,988,679.06	17,827,400.00
120	Нийтлэг татварын бус орлого	121,988,679.06	17,827,400.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	121,988,679.06	17,827,400.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	103,335,679.06	11,153,400.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	18,653,000.00	6,674,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,205,986,600.00	3,008,197,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,923,642,200.00	2,673,392,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,923,642,200.00	2,673,392,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	282,344,400.00	334,804,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	282,344,400.00	334,804,700.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,106,913,777.26	2,898,189,574.86
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,106,913,777.26	2,898,189,574.86
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,976,628,420.37	2,770,173,850.19
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,420,561,420.85	1,994,816,259.27
210101	Үндсэн цалин	960,559,156.53	1,287,961,799.07
210102	Нэмэгдэл	402,970,219.24	624,815,420.20
210104	Урамшуулал	57,032,045.08	82,039,040.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	175,771,401.91	247,354,076.07
210201	Тэтгэврийн даатгал	120,762,854.78	168,642,733.48
210202	Тэтгэмжийн даатгал	14,207,212.30	20,204,085.53
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,321,949.83	10,049,292.28
210204	Ажилгүйдлийн даатгал	2,679,998.65	9,691,212.95
210205	Эрүүл мэндийн даатгал	26,799,386.35	38,766,751.83
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	273,659,503.11	329,803,931.33
210301	Гэрэл, цахилгаан	14,901,103.11	14,362,811.33
210302	Түлш, халаалт	244,832,400.00	291,573,100.00
210303	Цэвэр, бохир үс	13,926,000.00	23,868,020.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,375,000.00	5,000,000.00
210604	Урсгал засвар	4,375,000.00	5,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,516,830.00	47,555,938.26
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,115,430.00	6,500,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	13,401,400.00	41,055,938.26

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	80,744,264.50	145,643,645.26
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	60,642,064.50	119,474,645.26
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	20,102,200.00	26,169,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	130,285,356.89	128,015,724.67
2132	Бусад урсгал шилжүүлэг	125,975,460.00	128,014,956.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт,	125,975,460.00	128,014,956.00
2135	шилжүүлэг	4,309,896.89	768.67
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,309,896.89	768.67
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)- (2)	221,061,501.80	127,835,225.14
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	165,144,000.00	46,359,700.00
	Дотоод эх үүсвэрээр	165,144,000.00	46,359,700.00
222001	Тоног төхөөрөмж	73,504,000.00	42,279,700.00
223001	Бусад хөрөнгө	91,640,000.00	4,080,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-165,144,000.00	-46,359,700.00
145	Бусад эх үүсвэр		
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал		
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	55,917,501.80	81,475,525.14
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	161,571,474.16	217,488,975.96
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	217,488,975.96	298,964,501.10

4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31				/төгрөгөөр/	
Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь	оролцооны дүн
20... оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	744596274.90	439736469.74	1304737199.73		2489069944.37
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт		15959868.90			15959868.90
Тайлант үеийн үр дүн			39873482.40		39873482.40
20... оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	744596274.90	455696338.64	1344610682.13		2544903295.67

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31			/төгрөгөөр/		
Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Харьцуулалт
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,243,184,900.00	2,944,549,274.86	298,635,625.14	90.79
21	УРСГАЛ ЗАРДАЛ БАРАА, АЖИЛ	3,243,184,900.00	2,898,189,574.86	344,995,325.14	89.36
210	ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ Цалин хөлс болон	3,099,928,000.00	2,770,173,850.19	329,754,149.81	89.36
2101	нэмэгдэл урамшил	2,225,769,900.00	1,994,816,259.27	230,953,640.73	89.62
210101	Үндсэн цалин	1,485,976,200.00	1,287,961,799.07	198,014,400.93	86.67

210102	Нэмэгдэл	649,316,400.00	624,815,420.20	24,500,979.80	96.23
210104	Урамшуулал	90,477,300.00	82,039,040.00	8,438,260.00	90.67
	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	278,221,200.00	247,354,076.07	30,867,123.93	88.91
210201	Тэтгэврийн даатгал	189,190,500.00	168,642,733.48	20,547,766.52	89.14
210202	Тэтгэмжийн даатгал	22,257,700.00	20,204,085.53	2,053,614.47	90.77
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,128,800.00	10,049,292.28	1,079,507.72	90.3
210204	Ажилгүйдлийн даатгал	11,128,800.00	9,691,212.95	1,437,587.05	87.08
210205	Эрүүл мэндийн даатгал	44,515,400.00	38,766,751.83	5,748,648.17	87.09
	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	329,804,700.00	329,803,931.33	768.67	100
210301	Гэрэл, цахилгаан	19,509,600.00	14,362,811.33	5,146,788.67	73.62
210302	Түлш, халаалт	291,573,100.00	291,573,100.00		100
210303	Цэвэр, бохир ус	18,722,000.00	23,868,020.00	-5,146,020.00	127.49
	Хангамж, бараа материалын зардал				
2105	Нормативт зардал				
	Эд хогшил, урсгал				
2106	засварын зардал	5,000,000.00	5,000,000.00		100
210604	Урсгал засвар	5,000,000.00	5,000,000.00		100
2107	Томилолт, зочны зардал				
	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	67,914,200.00	47,555,938.26	20,358,261.74	70.02
	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил				
210801	үйлчилгээний төлбөр хураамж	6,500,000.00	6,500,000.00		100
	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	61,414,200.00	41,055,938.26	20,358,261.74	66.85
210806	Бараа үйлчилгээний бусад зардал	193,218,000.00	145,643,645.26	47,574,354.74	75.38
	Бараа үйлчилгээний бусад зардал	167,049,000.00	119,474,645.26	47,574,354.74	71.52
210901	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	26,169,000.00	26,169,000.00		100
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	143,256,900.00	128,015,724.67	15,241,175.33	89.36
2132	Бусад урсгал шилжүүлэг	143,256,900.00	128,014,956.00	15,241,944.00	89.36
	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	143,256,900.00	128,014,956.00	15,241,944.00	89.36
213205	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг		768.67	-768.67	
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг		768.67	-768.67	
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		46,359,700.00	-46,359,700.00	
	Дотоод эх үүсвэрээр		46,359,700.00	-46,359,700.00	
222001	Тоног төхөөрөмж		42,279,700.00	-42,279,700.00	
223001	Бусад хөрөнгө		4,080,000.00	-4,080,000.00	
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ				
1	ҮҮСВЭР	3,026,024,800.00	3,026,024,800.00		100
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,673,392,700.00	2,673,392,700.00		100
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,673,392,700.00	2,673,392,700.00		100
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого				
	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС				
132	САНХҮҮЖИХ	334,804,700.00	334,804,700.00		100
132001	Орон нутгийн төсвөөс	334,804,700.00	334,804,700.00		100
133	ТӨСВИЙН ЗАХИРАГЧДААС				

НИЙГМИЙН ДААТГАЛЫН				
134	САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ			
120004	АЖИЛЛАГААНААС	17,827,400.00	17,827,400.00	100
	Үндсэн үйл ажиллагааны			
1200041	орлогоос санхүүжих	11,153,400.00	11,153,400.00	100
	Туслах үйл ажиллагааны			
1200042	орлогоос санхүүжих	6,674,000.00	6,674,000.00	100
124	БУСАД ЭХ ҮҮСВЭР			
	Мөнгө, түүнтэй адилтгах			-
31	хөрөнгийн эхний үлдэгдэл		217,488,975.96	217,488,975.96
	Мөнгө, түүнтэй адилтгах			-
31	хөрөнгийн эцсийн үлдэгдэл		298,964,501.10	298,964,501.10
	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН			
1	АНГИЛАЛ			
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО			
3	Төсвийн байгууллага		1	1
5	АЖИЛЛАГСАДЫН ТОО		79	79
6	Удирдах ажилтан		1	1
7	Гүйцэтгэх ажилтан		64	64
8	Үйлчлэх ажилтан		14	14

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Улиастай сумын Дэвшил сургуулийн үйл ажиллагааны чиглэл:

- Боловсролын үйлчилгээ үзүүлэх

Улиастай сумын Дэвшил сургуулийн зорилго: Эрүүл зөв дадал бүхий сурлагын ахицтай суралцагчийг бий болгох

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 60 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 97.5 хувийн гүйцэтгэлтэй гэж үнэлсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Улиастай сумын Дэвшил сургуулийн үйл ажиллагаанд мөрддөг хууль:

1. Боловсролын багц хууль
2. Төрийн албаны тухай хууль
3. ЗГ-ын 39,53,25,104-р тогтоолууд
4. Төсвийн тухай хууль
5. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
6. Нийгмийн даатгалын ерөнхий хууль
7. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
8. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
9. Хөдөлмөрийн тухай хууль
10. Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ. Дотоод хяналтын багийг байгуулж,

төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. Мөн Санхүүгийн өдөр тутмын ажил гүйлгээнд төсөв, төрийн сангийн мэргэжилтэн нар хяналтыг хийж байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улиастай сумын Дэвшил сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Улиастай сумын Дэвшил сургууль 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө өмнөх оноос 140,692.25 мянган төгрөгөөр буюу 60 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	82.00	0	82.00
Бараа материал	115,862.38	189,637.36	73,774.98
Үндсэн хөрөнгө	2,155,635.65	2,141,160.32	14,475.33
Нийт хөрөнгө	2,489,069.94	2,629,762.19	140,692.25
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,489,069.94	2,629,762.19	140,692.25
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,489,069.94	2,629,762.19	140,692.25

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

Тайланд онд:

Авлагын эхний үлдэгдэл 82.9 мянган төгрөг, тайлант онд 82.9 мянган төгрөгийн авлага барагдсан.

Бараа материалын эхний үлдэгдэл 115,862.3 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр 319,976.16 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, хандиваар 23,078.80 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүйгээр нэмэгдэж, 269,279.98 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, эцсийн үлдэгдэл 189,637.36 мянган төгрөг болж, өмнөх оноос 73,774.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгийн хувьд төсвийн хөрөнгөөр 96,592.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, хөрөнгө оруулалтаар 49,144.69 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүйгээр нэмэгдэж, 62,397.67 мянган төгрөгийн хөрөнгийг шийдвэрийн дагуу акталж, 15,959.86 төгрөгийн хөрөнгийг

шийдвэрийн дагуу хугацааг сунган, үнэ шинэчлэн тогтоосон, жилийн эцэст 2,684,743.42 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Тайлант оны элэгдлийн зардалд 171,682.24 мянган төгрөгийг тооцож бүртгэсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,673,392.70 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 334,804.70 нийт зарлагыг 3,008,197.40 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 12 арга хэмжээг санхүүжүүлэхээр 0.768 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх шилжүүлэг хийсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,944,549.27 мянган төгрөг буюу 90.79 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

<i>/мянган төгрөгөөр/</i>					
Хөтөлбөр арга хэмжээ	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
Улсын төсөв болон орон нутгийн төсвөөс санхүүжих					
80109	Орон нутгийн санхүүжилт	334,804.70	334,804.70	0.0	100.0
81834	Боловсролын стандарт сургалт, сургалтын төлөвлөгөө стандарт хэрэгжүүлэх	2,516,748.40	2,269,372.00	247376.40	90.17
81801	Үдийн хоол хөтөлбөр	143,256.90	128,202.90	15054.00	89.49
80233	Хүүхэд хамгаалал	6,771.00	6,767.70	3.30	99.95
80226	Байр ашиглалтын зардал	6,542.30	6,542.30	0.00	100.00
80312	Сургалт ,семинар	7,831.50	3,155.20	4676.30	40.29
81605	Эрүүл мэндийг дэмжих	6,642.30	6,539.00	103.30	99.95
81816	Нөхөн хангалт	72,528.30	72,528.30	0.00	100.00
81823	Багш, ажилчдын мэргэжил дээшлүүлэх	19663.20	12215.50	7447.70	62.12
81835	Багш нарын урамшуулал	87,809.00	70,719.25	17089.75	80.54
81844	Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн сургалт	11,000.00	10,162.00	838.00	92.38
81848	Сурах бичгийн түрээс	6,500.00	7,665.40	-1165.40	117.93
81875	Нэмэлт сургалтын хөтөлбөр	12,093.20	5,947.03	6146.17	49.18
83603	Дээд дээд шатны төсвөөс хувиарласан	118.0	118.0	0.00	100.00
	Нийт дүн	3,243,184.90	2,944,549.27	298635.63	90.79

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 2023 оны сургалтын төлбөрийн үлдэгдэл 3,488.0 мянган төгрөг, заалны орлого 6,674.0 мянган төгрөг нийт 10,162.0 мянган төгрөгийг сургалтын орчин сайжруулахаар зарцуулсан байна.

Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

/мянган төгрөг/

№	Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан арга	Бараа ажил үйлчилгээний нэр	Төлөвлөлт	Гүйцэтгэл
1	Нээлттэй тендер шалгаруулалт	Үдийн хоол хөтөлбөр	121,684.70	37,397.20
ДҮН			121,684.70	37,397.20

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Улиастай сумын Дэвшил сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Хаан соёмбо аудит ХХК”-ны гэрээт аудитор Б.Цэрэндэжид гүйцэтгэж, анхан шатны хяналтыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Оюунсүвд хийж, чанарын хяналтыг аудитын менежер Х.Болдбаатар, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Улиастай сумын Дэвшил сургууль нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 14-ны өдрийн 05 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг 3,053,885.1 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 45,808.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 34,356.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 31 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд алдаа, зөрчил илрээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2024 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 5 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Улиастай сумын Дэвшил сургуулийн 2024 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгдэж анхан шатны баримтгүй болон анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэн тайлагнасан зөрчил, анхны өртгөө элэгдлээрээ нөхсөн тэг үлдэгдэлтэй байгаа хөрөнгийг дахин үнэлж ашиглалтын хугацааг сунгаагүй, хоолны зардлыг нормативаас илүү зарцуулсан зэрэг зөрчлүүд илэрч зөвлөмжийг хүргүүлэн хэрэгжилтийг бүрэн хэрэгжүүлсэн.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 200.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгөгдсөнийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	-	-	-	-	-
Зөвлөмж	1	200.0	1	200.0	100%
Нийт дүн	1	200.0	1	200.0	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал тодорхойлогдоогүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,588.4 мянган төгрөгийн алдаа илэрч зөвлөмж өгч завсрын болон аудитын явцад бүрэн хэрэгжилтийг хангуулсан.

Залруулсан алдаа:

Байхгүй

Шийдвэрлэсэн байдал: Байхгүй

5.1 Төлбөрийн акт тогтоогоогүй

5.2 Албан шаардлага: өгөгдөөгүй

5.3 Зөвлөмж

- **Илэрсэн алдаа:** Хүүхдийн үдийн хоолыг нормативт зардлаас 2,588.4 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан.
- **Шийдвэрлэсэн байдал:** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх" заалт, Засгийн газрын 2019 оны 450, 2024 оны 237 дугаар тогтоолуудыг хэрэгжүүлэн ажиллах

Энэхүү зөвлөмжийг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасны дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг түвшингөөс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:


АХУГАХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

БОЛОВСРУУЛСАН:

Огноо

2025-02-12



Д.БАТ-УНДРАА

"УААН СОЁМО АУДИТ" ХХК ГЭРЭЭТ АУДИТОР

Огноо: 2025-02-12

Б.ЦЭРЭНДЭЖИД